



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/10

Хэрлэн сум

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Иргэний хуулийн 64, 65 дугаар зүйл заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тулга констракшн" ХХК-аас аймгийн орон сууцны санд төлөх 274,581,171 (хоёр зуун далан дөрвөн сая таван зуун наян нэгэн мянга нэг зуун далан нэгэн) төгрөгийн нэхэмжлэх тухай иргэний хэрэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.1.4, 25.1.5, 25.1.6, 25.1.7, 25.1.8 дахь заалтуудад заасан бүрэн эрхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбатаар)-д олгож, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр (хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар) томилсугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нэхэмжлэгчийг бүрэн төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР